



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/486

Ховд

Гуравдугаар цэцэрлэгийн барилгын  
дээврийн засварын ажлыг хүлээн авах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Ланз” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн 3 дугаар цэцэрлэгийн барилгын дээврийн засварын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Туулайтулга	- Жаргалант сумын Засаг даргын орлогч
Гишүүд: Д.Нямтулга	- Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч
Б.Түмэндэмбэрэл	- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Ц.Цолмонбаатар	- Стандарт, хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн
И.Цэрмаа	- Жаргалант сумын Наран багийн Засаг дарга
Б.Бурмаа	- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
С.Батдорж	- Аймгийн Архивын тасгийн дарга
Ч.Лхагвацэрэн	- “Ланз” ХХК-ийн захирал
Ц.Ганцэцэг	- 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Нарийн бичгийн  
дарга: Д.Тогтохбаяр

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн  
ахлах мэргэжилтэн

2. “Ланз” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо  
хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр  
гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН